



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ын 3.2-т заасныг тус тус үндэслэн Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх чиглэлээр:

1.1 “КАДРИ түншлэл (CADRI-Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл)”-ээс Монгол Улсад хийсэн “Уур амьсгал, гамшгийн эрсдэлийг удирдах чадавх”-ын үнэлгээнээс гарсан зөвлөмж, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн бүсийн төлөвлөгөө 2024-2027”, Гамшгийн эрсдэлийг бууруулахад бүх талуудыг хамруулах ялангуяа хувийн хэвшил, бизнес, банк, санхүү, даатгалын байгууллага, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жендерийн тэгш байдлыг хангах үндэсний болон олон улсын иргэний нийгмийн байгууллагын манлайллыг нэмэгдүүлэх агуулгыг Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн гуравдугаар үе шатны 2026-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон салбарын хөгжлийн баримт бичигт тусгаж, хэрэгжүүлэх (Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд)

1.2 Үндэсний хэмжээнд “20 минутын хот”, “14 мега төсөл”, “Боомтын сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэхэд гамшгийн эрсдэлийг тооцож, хот төлөвлөлт дагасан болон боомтын аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлын хүрээнд онцгой байдлын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, шинээр барьж байгуулах аврах анги, нэгжийн судалгааг хийж танилцуулах (Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл)

1.3 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэг, их дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон хүүхэд залуучуудад үйлчлэх төвүүдэд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх (Онцгой байдлын ерөнхий газар, Боловсролын яам)

1.4 Гамшгийн үед түр хоргодох байраар ашиглагдах сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангах хүрээнд шаардлагатай бүх төрлийн нөөцийн тооцоо судалгааг гаргаж, бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах (Боловсролын яам, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл)

1.5 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т заасан гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, түүний зарцуулалтад (үр ашгийн) дүн шинжилгээ хийж ГЭБҮЗ-д танилцуулах (Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам)

1.6 "Химийн хорт болон аюултай бодис, газрын тосны бүтээгдэхүүн, ахуйн болон бусад зориулалтын шатамхай хийг экспортлох, импортлох, тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах аюулгүй байдлын стандартыг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг байгуулж, дүнг танилцуулах (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрчим хүчний яам)

1.7 Аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшил нь өөрсдийн гамшгийг даван туулах чадавхаа бий болгох, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гарааны бизнесийг хөгжүүлэх, урамшуулах, хэрэглээний инновацыг хөгжүүлэх (Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим)

Хоёр: Барилга, дэд бүтцийн гамшигт тэсвэртэй байдлыг хангах чиглэлээр:

2.1. Улсын хэмжээнд 2002 оноос өмнө баригдсан эмнэлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байрны 1760 барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулахад шаардагдах 17,6 тэрбум төгрөг, үл эвдэх сорилын багажны 630 сая төгрөг, нийт 18,2 тэрбум төгрөгийг шийдвэрлэх (Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар)

2.2. Улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй газар хөдлөлтөд тэсвэргүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн 127 барилгыг буулгаж шинээр барихад шаардлагатай 492 тэрбум төгрөгийг жил бүрийн төсөвт суулгаж шийдвэрлэх, санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх (Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар)

2.3. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын санхүүжилтээр газар хөдлөлтөд тэсвэргүй 10 сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг хүчитгэх (Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам)

2.4. Үерийн эрсдэл өндөр хот суурин газруудад эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан үерээс хамгаалах инженерийн байгууламж, борооны ус зайлуулах шугам сүлжээ, дэд бүтцийг сайжруулан шинэчлэх, шаардагдах төсвийг үе шаттай төсөвт тусгах, шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх (Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл)

2.5. "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд нэн тэргүүнд хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийг тодорхойлж зураг төслийг боловсруулсан 4 барилга байгууламжийн хүчитгэлийн санхүүжилтийг шийдвэрлэх (Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам)

2.6. Булган, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд аймгийн төвийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх (Сангийн яам)

Гурав. Гамшгийн зарлан мэдээлэл, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр:

3.1. Зарлан мэдээллийн системийг Олон улсын түвшинд нийцэхүйц сорс кодтой шинэ систем, техник, технологийг нэвтрүүлэх, программ хангамжийн

шинэчлэлт хийх (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Онцгой байдлын ерөнхий газар)

3.2. Хонхорын радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлэх, хэт богино долгионы радио сүлжээг DAB+ тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулахад шаардагдах 11.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт үе шаттай тусгаж хэрэгжүүлэх (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам)

3.3. Гамшгийн зарлан мэдээллийг хүн бүрд нээлттэй, хүртээмжтэй хүргэх хүрээнд шинээр суурилуулах шаардлагатай цамхгийн тооцоо судалгааг гаргаж, цамхгийн тоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах (Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар)

Дөрөв. Боловсролын салбарын гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр:

4.1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн агуулга, хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн агуулгыг шинэчилж гамшгаас хамгаалах боловсрол олгох талаар тусгаж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих (Боловсролын яам, Онцгой байдлын ерөнхий газар)

4.2. “Монгол хүн ба эрсдэлийн боловсрол” аяныг бүх нийтийн дунд өрнүүлэх, үүнд шаардагдах 1,2 тэрбум төгрөгийг шийдвэрлэх хүрээнд Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх (Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн Ажлын алба, Боловсролын Яам, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл)

4.3. НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас санаачилсан “Сургуулийн цогц аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийг 2030 он хүртэл хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, үүрэг амлалтыг биелүүлэхэд ахиц дэвшил гаргах, үе шаттай төлөвлөж хэрэгжилтийг хангах (Боловсролын яам, Онцгой байдлын ерөнхий газар)

4.4. Жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Лхагва гаригт “Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах өдөр”, Пүрэв гаригт “Газар хөдлөлтийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах өдөр”-ийг ЕБС-ийн сурагчдын бие даалтын долоо хоногтой нийцүүлэн гамшгийн эрсдэлийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах (Боловсролын яам, Онцгой байдлын ерөнхий газар)

Тав. Байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр.

5.1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хавар намрын үед зогоон татах, орон нутгийн түвшинд түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, тэдгээрт шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэх (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар)

5.2. Улсын хэмжээнд 20 аймгийн 287 суманд 287 гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулагдан 4438 хүний бүрэлдэхүүнтэй, 60 ширхэг гал түймэр унтраах зориулалтын автомашинтай үйл ажиллагаа явуулж байна. Тус сайн дурын хэсгийн техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хүрээнд ой, хээрийн гал түймэр унтраах шуурхай албаны автомашин, гал түймэр унтраах багаж, холбооны хэрэгсэл, хамгаалах тусгай хувцасны нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох хөрөнгийн шийдвэрлэх (Сангийн яам, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар)

Зургаа. Хөдөө аж ахуйн салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр:

6.1. Улсын хэмжээнд зудын эрсдэлийн үнэлгээг хийж, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах хүрээнд эрт арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар)

6.2. Зудын эрсдэлийг бууруулах, зудын гамшигтай тэмцэх арга хэмжээг сайжруулах хүрээнд үндэсний хэмжээний стратегийг боловсруулах (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар)

6.3. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний дэгдэлтийг эрт тандан илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, шийдвэр гаргахад шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг бүрдүүлэх (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар)

Долоо. Эрчим хүчний салбарын гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хүрээнд:

7.1. Эрчим хүчний салбарт гамшгийн эрсдэлийн үнэлгээг системийн түвшинд хийхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх (Эрчим хүчний яам, Сангийн яам)

7.2. Эрчим хүчний доголдол үүсэх онцгой нөхцөл байдлын үед хоногийн 24 цагийн турш ажиллах боломж бүхий шуурхай ажиллагааны холбоо, хяналт мэдээллийн системээр тоноглогдсон диспетчерийн шуурхай удирдлагын нөөц байр бий болгох (Эрчим хүчний яам)

7.3. Эрчим хүчний хямралын үед дулааны цахилгаан станцын дотоод хэрэгцээг сэргээх нөөц эх үүсвэр суурилуулах (Эрчим хүчний яам)

Найм. Уул уурхайн салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр:

8.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ил, далд уурхай, орд газруудад гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам)

Ес. Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

9.1. Газрын тосны бүтээгдэхүүн, аюултай хорт бодис тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд хяналт тавьж зөвшөөрөл олгох, тээвэрлэлтийн аюулгүй байдалд хяналт тавих эрх зүйн орчныг боловсронгуй болгох (Зам тээврийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар)

Арав. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн Ажлын албанд:

10.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2025 оны хуралдаанд танилцуулах (Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн Ажлын алба, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл)

10.2. Хуралдааны шийдвэрээс Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээг Шадар сайдын Ажлын албанд 2025 оны 01 дүгээр улиралд танилцуулах.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

С.АМАРСАЙХАН

